



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Л.Уранбилэг
Утас: 70593208
Цахим хаяг: Uranbilegl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

0

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
/төгрөгөөр/.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	8
4.1 Ерөнхий зүйл.....	8
4.2 Материаллаг байдал.....	8
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	8
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
4.5.1 Завсрын аудитын талаар.....	9
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Албан шаардлага.....	10
1. Зөрчлийн агуулга	Error! Bookmark not defined.
Өмнөх оны түлш халаалтын өглөгийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.....	10
2. Зөрчлийн агуулга	Error! Bookmark not defined.
Интернэтийн төлбөрийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлж эдийн засгийн ангилал зөрчсөн.	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайшагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.25 № 20
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Х.ЦЭРЭН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 159.3 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 52 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 98.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

4825020071

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,229,077.27	267,819,365.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	31,701,037.16	193,598,996.76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	31,701,037.16	193,598,996.76
3121	Төгрөг	31,701,037.16	193,598,996.76
31211	Төрийн сангийн харилцах	31,428,611.16	193,326,570.76
31218	Ахмадын сангийн харилцах	272,426.00	272,426.00
33	АВЛАГА	-	6,552,419.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	6,552,419.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,528,040.11	67,667,949.71
351	Түүхий эд материал	36,122,444.55	38,944,244.55
35110	Тусгай зориулалттай материал	36,122,444.55	38,944,244.55
354	Хангамжийн материал	17,405,595.56	28,723,705.16
35420	Аж ахуйн материал	11,011,505.56	12,795,105.56
35450	Барилгын засварын материал	-	5,100,000.00
35460	Хүнсний материал	6,394,090.00	10,828,599.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,155,996,469.29	1,180,546,121.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,155,996,469.29	1,180,546,121.26
392	Биет хөрөнгө	1,136,346,469.29	1,149,496,121.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,093,368,928.75	1,093,368,928.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,033,569.27)	(120,810,173.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,216,355.15	106,405,355.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,363,426.92)	(27,315,641.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,776,786.80	97,846,170.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,587,549.66)	(21,916,304.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,050,000.00	23,014,844.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(81,055.56)	(1,097,056.32)
393	Биет бус хөрөнгө	19,650,000.00	31,050,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,650,000.00	31,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,241,225,546.56	1,448,365,486.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,298,355.00	980,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,298,355.00	980,700.00
413	Өглөг	10,298,355.00	980,700.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,298,355.00	980,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,230,927,191.56	1,447,384,786.73
51	Засгийн газрын хувь оролцоо	1,230,927,191.56	1,447,384,786.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	271,161,535.52	271,161,535.52
51101	Өмч: - төрийн	271,161,535.52	271,161,535.52
512	Хуримтлагдсан үр дүн	751,631,860.99	968,089,456.16
51210	Өмнөх үеийн үр дүн	751,631,860.99	757,830,215.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	210,259,240.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	208,133,795.05	208,133,795.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,241,225,546.56	1,448,365,486.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,078,257,900.00	1,676,510,266.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,310,000.00	80,285,566.40
120	Нийтлэг татварын бус орлого	52,310,000.00	80,285,566.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,779,022.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,779,022.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	52,310,000.00	73,943,944.00

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	1,562,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025,947,900.00	1,596,224,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	892,371,800.00	1,479,762,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	892,371,800.00	1,479,762,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,672,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,672,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,904,100.00	116,462,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,904,100.00	116,462,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,016,615,624.52	1,464,611,026.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,016,615,624.52	1,464,611,026.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,014,500,698.76	1,446,161,385.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,465,073.21	968,280,288.00
210101	Үндсэн цалин	411,248,701.37	602,686,277.00
210102	Нэмэгдэл	170,983,487.89	301,213,099.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,602,500.00	-
210104	Урамшуулал	23,630,383.95	64,380,912.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,998,750.44	121,827,820.00
210201	Тэтгэврийн даатгал	52,547,510.00	82,851,354.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,150,051.86	9,744,130.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,591,458.50	5,462,158.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,348,066.36	4,111,599.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,361,663.72	19,658,579.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,388,459.24	98,407,958.91
210301	Гэрэл, цахилгаан	6,786,004.24	5,845,583.91
210302	Түлш, халаалт	76,102,455.00	84,366,975.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	8,195,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,323,300.00	19,470,309.00
210401	Бичиг хэрэг	5,279,570.00	7,382,139.00
210402	Тээвэр, шатахуун	3,121,930.00	3,875,270.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,921,800.00	8,212,900.00
2105	Нормативт зардал	130,150,420.00	150,689,207.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	350,000.00	479,500.00
210502	Хоол, хүнс	129,800,420.00	150,209,707.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,599,070.00	11,276,700.00
210604	Урсгал засвар	14,599,070.00	11,276,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,024,000.00	6,822,000.00
210702	Дотоод албан томилолт	1,024,000.00	6,822,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,130,000.00	2,191,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,130,000.00	2,191,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,421,625.87	67,195,202.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,205,200.00	7,667,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	532,580.00	5,781,510.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,683,845.87	53,745,892.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,114,925.76	18,449,641.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,771,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	16,771,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,114,925.76	1,677,741.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,114,925.76	1,677,741.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	61,642,275.48	211,899,240.13
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,639,999.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,639,999.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,639,999.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	61,642,275.48	210,259,240.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,025,947,900.00	1,601,003,722.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,779,022.40
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,779,022.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,779,022.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,779,022.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,025,947,900.00	1,596,224,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	892,371,800.00	1,479,762,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	892,371,800.00	1,479,762,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,672,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,672,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,904,100.00	116,462,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,904,100.00	116,462,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	966,266,243.65	1,433,114,162.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,266,243.65	1,433,114,162.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	953,295,317.89	1,414,664,521.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,465,073.21	974,832,707.00
210101	Үндсэн цалин	411,248,701.37	609,238,696.00
210102	Нэмэгдэл	170,983,487.89	301,213,099.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,602,500.00	-
210104	Урамшуулал	23,630,383.95	64,380,912.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,998,750.44	121,827,820.00
210201	Тэтгэврийн даатгал	52,547,510.00	82,851,354.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,150,051.86	9,744,130.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,591,458.50	5,462,158.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,348,066.36	4,111,599.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,361,663.72	19,658,579.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,190,104.24	98,407,958.91
210301	Гэрэл, цахилгаан	6,786,004.24	5,845,583.91
210302	Түлш, халаалт	69,904,100.00	84,366,975.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	8,195,400.00
2105	Нормативт зардал	123,060,510.00	154,082,200.00
210502	Хоол, хүнс	123,060,510.00	154,082,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,599,070.00	16,376,700.00
210604	Урсгал засвар	14,599,070.00	16,376,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,386,900.00	2,191,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,386,900.00	2,191,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,594,910.00	46,945,235.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,597,760.00	35,525,836.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,997,150.00	11,419,399.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,970,925.76	18,449,641.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,856,000.00	16,771,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,856,000.00	16,771,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,114,925.76	1,677,741.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,114,925.76	1,677,741.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	59,681,656.35	167,889,559.60
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,816,000.00	5,991,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,816,000.00	5,991,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,816,000.00	5,991,600.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,816,000.00	5,991,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(28,816,000.00)	(5,991,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	30,865,656.35	161,897,959.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	835,380.81	31,701,037.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,701,037.16	193,598,996.76

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	271,161,535.52	208,133,795.05	689,989,585.51	1,169,284,916.08
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,161,535.52	208,133,795.05	689,989,585.51	1,169,284,916.08
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	61,642,275.48	61,642,275.48
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,161,535.52	208,133,795.05	751,631,860.99	1,230,927,191.56
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	271,161,535.52	208,133,795.05	751,631,860.99	1,230,927,191.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	6,198,355.00	6,198,355.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,161,535.52	208,133,795.05	757,830,215.99	1,237,125,546.56
D04	Тайлант үеийн үр дүн			210,259,240.17	210,259,240.17
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,161,535.52	208,133,795.05	968,089,456.16	1,447,384,786.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		31,428,611.16
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,637,976,100.00	1,437,428,021.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,637,976,100.00	1,437,428,021.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,621,204,200.00	1,420,656,121.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,136,244,400.00	974,832,707.00
210101	Үндсэн цалин	751,114,200.00	609,238,696.00
210102	Нэмэгдэл	358,205,200.00	301,213,099.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	26,925,000.00	64,380,912.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,261,800.00	121,827,820.00
210201	Тэтгэврийн даатгал	87,901,300.00	82,851,354.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,337,700.00	9,744,130.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,170,300.00	5,462,158.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,170,300.00	4,111,599.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,682,200.00	19,658,579.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,062,400.00	98,407,958.91
210301	Гэрэл, цахилгаан	7,500,000.00	5,845,583.91
210302	Түлш, халаалт	84,367,000.00	84,366,975.00

210303	Цэвэр, бохир ус	8,195,400.00	8,195,400.00
2105	Нормативт зардал	168,553,000.00	154,082,200.00
210502	Хоол, хүнс	168,553,000.00	154,082,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,400,000.00	16,376,700.00
210604	Урсгал засвар	16,400,000.00	16,376,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,274,100.00	2,191,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,274,100.00	2,191,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,408,500.00	52,936,835.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,957,100.00	41,517,436.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,451,400.00	11,419,399.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,771,900.00	18,449,641.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,771,900.00	16,771,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,771,900.00	16,771,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,637,976,100.00	1,599,325,981.31
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,479,968,700.00	1,479,762,300.00
122005	Улсын төсвөөс санхүүжих	1,479,968,700.00	1,479,762,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	147,299,100.00	-
132001	Орон нутгийн төсвөөс	116,462,400.00	114,784,658.91
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутаг/	30,836,700.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,708,300.00	4,779,022.40
120010	Туслах үйл ажиллагааны орлого	10,708,300.00	4,779,022.40
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	31,428,611.16
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	193,326,570.76

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Уранбилэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ, газрын дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүү, үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,464,611.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,646.1 мянган төгрөгөөр тогтоосон ба гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоогоогүй болно.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 34 горим сорилыг төлөвлөж, хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй. Нийт батлагдсан төсвийн 86.9 хувийг зарцуулж, 193,326.5 мянган төгрөгийг харилцах дансны үлдэгдэлтэй байна. Хэмнэлтийн дийлэнх хувь нь цалин хөлс болон

нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх шимтгэл, хоол хүнсний зардал, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт байна.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагын хэрэгжилтэд хийсэн аудитад 25 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 онд нийт 1,059,494.4 мянган төгрөгийн 67 удаагийн гүйлгээ, шийдвэрийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулж, хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байсан.

3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж өмнөх оны 6,198.3 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн байна.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн алдааг давтан гаргахгүй хянаж ажиллах зөвлөмж өгч, биелэлт 100 хувьтай хэрэгжсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	145.5	1	145.5	100.0
Нийт дүн	1	145.5	1	145.5	100.0

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар эд хөрөнгийн хяналтын тооллого хийж, биет горим хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,739.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад залруулсан алдаа байхгүй, 7,713.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 5,026.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 12,739.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, албан шаардлага, зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4.1 Албан шаардлага

1. Өмнөх оны түлш халаалтын өглөгийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ гэж заасныг;

2. Интернэтийн төлбөрийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлж эдийн засгийн ангилал зөрчсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолын 4- дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх" журмын 8.5.-д /Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээнд үндэслэн олгосон санхүүжилтийг зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах үүрэгтэй/ заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй албан шаардлагыг хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Байгууллагын удирдлага нь нягтлан бодогч, няравт нарт албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан, 2023 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр 5,026.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/, 15.1.3-т /Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3-т /мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид/ олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна. Мөн 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй гэж заасныг мөн нийцсэн ба зохистой байх мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан арга хэмжээгээр давхардуулан урамшуулал олгохгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан үр бүтээл гаргасан гэдгийг нотлох баримттай, тодорхой шалгуурыг хангасан тохиолдол урамшууллыг олгож хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны түлш халаалтын өглөгийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	6,198.3			1	6,198.3				
Интернэтийн төлбөрийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлж эдийн засгийн ангилал зөрчсөн	1	1,515.2			1	1,515.2				
2023 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан үндэслэлээр нягтлан бодогч няравт үр дүнгийн урамшууллыг давхардуулан тооцож олгосон	1	5,026.0					1	5,026.0		
Дүн	3	12,739.5	-	-	2	7,713.5	1	5,026.0	-	-